

ҮНДЭСНИЙ ЭРХ АШИГ, УЛС ОРНЫ НЭР ТӨРИЙГ ХАМГААЛАХАД ДИПЛОМАТУУДЫН ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

Д. Цолмон*

Монгол улсын Дипломат алба үүсэн байгуулагдсаны 95 жил, тус улсын гадаад албыг олон жил удирдаж, дараа нь ОУХС-ийн суурийг тавихад сэтгэл гарган оролцсон ууган дипломат, М.Дүгэрсүрэнгийн мэндэлсний 85 насны ойд зориулсан энэхүү эрдэм шинжилгээний хурал Монгол улсын анхны мэргэжлийн дипломат, төрийн зүтгэлтэн, сурган хүмүүжүүлэгчийн амьдрал, туулсан замналын тухай дипломатууд, судлаачдын санал солилцох сайхан боломж олгож байна.

Баянхонгор аймгийн Галуут сумын уугуул Дүгэрсүрэн гуай Алтай, Хангайн уулсын адил нуруутай, нөмөр нөөлөгтэй хүн байсныг түүний гараар өсч өндийсөн миний үеийнхэн сайн мэднэ. Өнөөдрийн бага хуралд хүрэлцэн ирсэн хүндэт зочид, түүний нэг ангийн оюутан агсан эрдэмтэн, манай эрдэмтэн багш нарын болон дипломат албаныхны тавьсан илтгэлээс үзэхүл Мангалын Дүгэрсүрэнгийн үүсгэн байгуулсан МУИС-ийн ОУХС-ийн оюутан, магистрант, докторант, багш нарт Монгол улсын гадаад бодлого, дипломат үйл ажиллагааны зангилаа асуудлаар санал солилцож онол практикийн болон сургалт, эрдэм шинжилгээний ач холбогдолтой, мөн дипломат ажилтнууд, оюутан залуусын эх оронч хүмүүжил, үндэсний эрх ашгаа дээдэлж ажиллахад ч сургамж болно гэж бодож байна.

Үндэсний эрх ашгийн тухай ойлголтыг задалж үзвээс дэлхий дахины улс гүрнүүдтэй мөр зэрэгцэн алхахдаа Монголынхоо газар нутгийн бүрэн бүтэн байдал, тусгаар тогтнолыг хамгаалан бэхжүүлэх, эдийн засаг, улс төр, оршин тогтнохын аюулгүй байдлаа улс төр, дипломатын аргаар хамгаалах асуудал юм. Сонгодог дипломат үйл ажиллагааны уламжлалтай Английн ерөнхий сайд агсан Лорд Пальмерстон “Мөнхийн дайсан, бас мөнхийн нөхөр гэж байдаггүй гагцхүү Британийн ашиг сонирхол л мөнх

* МУИС, ОУХС-ийн тэргүүлэх профессор, доктор

орших болно” гэж тэмдэглэн үлдээснийг Уйнстон Черчилль давтан өгүүлж байсан нь учиртай.

Үндэсний эрх ашгаа дээдлэн хамгаалах нь төрийн түшээд, дипломатууд, иргэдийн эх оронч үзэл, хүмүүжил үүрэг хариуцлагатай холбоотой асуудал мөн. “Эх оронч үзэлгүй хүнд эрдэм сургаваас босоо ороолонд алтан шүд зүүж өгсөнтэй адил” хэмээн мэргэдийн сургаальд өгүүлдэг.

Дүгэрсүрэн гуай 1955 онд Энэтхэгийн нэрт улс төрийн зүтгэлтэн ерөнхий сайд агсан Жавхарлал Нерутай уулзахдаа: Би эх оронч хүний хувьд Монгол улсыг НҮБ-д элсүүлж аваасай гэж ямагт бодож явдаг гэж хэлсэн үг нь баримт болон үлджээ. Монгол улсын гадаад хэрэг явдлыг мэргэжлийн түвшинд явуулах, дипломат ажилтны залгамж халааг бэлтгэхэд түүний оруулсан хувь нэмрийг мартаж огт болохгүй гэж би хувьдаа боддог юм. Дүгэрсүрэнг гадаад албыг тэргүүлж байх үед л Монгол улс өрнөдийн нөлөө бүхий гол улс гүрнүүдтэй дипломат харилцаа тогтоож улсаа гадаад ертөнцөд бүрэн утгаар нь хүлээн зөвшөөрүүлэх алхамууд хийгдсэн шүү дээ.

Зарим нэг хүн АНУ-тай дипломат харилцаа тогтооход “Дүгэрсүрэн саад болоод байсан” мэтээр бичиж байгаа нь арьсаа хамгаалсан, талийгаачийн тухай олон түмэнд буруу сэтгэгдэл төрүүлэх гэсэн оролдлого гэж бодно. Би яг тэр ажлыг Дүгэрсүрэнгийн удирдлагаар гардан хариуцаж хэрэгжүүлсэн хүний хувьд, Монгол Америкийн харилцааны түүхэн лавлахыг нь бичиж үлдээсэн хүний хувьд бодит үнэнийг баттай өгүүлж чадна.

“Том Вето” ЗХУ-ынхаа даалгавраар тус улсын тусгай албадтай холбоотой байсан зарим нөхөд л хамаг баримт сэлтээ зөвлөлтийнхөнд өгч мэдээлж байснаа эргэн санахад илүүдэхгүй. Зөвлөлтийн талаас харилцаа тогтоох асуудалд ГХЯ-ны сайд нь биеэрээ ирж албан ёсоор мэдэгдээд байхад нам, төрийг тэргүүлж байсан хүн зөвшөөрлийг нь бичгээр дахин ав гэж цохсоныг Дүгэрсүрэн гуай уншиж үзээд толгой сэгсэрч суусныг нүдээрээ үзсэн хүмүүс бий. Дүгэрсүрэн багш бүх баримт сэлтийг хэнд ч өгөлгүй, өөрөө хариуцаж нягталж байх үүргийг надад даалгасан юм. Тэгтэл ЗХУ-ын ЭСЯ-ныхан Америктай харилцаа тогтоохтой холбоотой бүх баримт сэлт миний сейфэнд байгааг мэдсэн байж билээ. Бидний боловсруулсан баримт сэлтийг өөрийн биеэр үзэж засаж суухдаа уг ажлыг бүтээхэд үнэхээр хүчин чармайлт гаргаж байсан юмдаг.

Дүгэрсүрэн зарчимч өндөр шаардлагатай, төрийн гадаад харилцааны баримт бичиг боловсруулах, дэг журам сахиж явах талаар залуучуудад үнэхээр үлгэр дууриалтай

нэгэн байж билээ. Түүний өндөр шаардлага, шулуун шударга занд дүргүүцдэг хүмүүс ч цөөнгүй байсан. Тэд гол төлөв мэргэжлийн бус, янз бүрийн татаасаар дипломат албанд орж ирсэн нутгархдаг, цаанаа дэмжлэгтэй хүмүүс байсан нь тодорхой. МУИС-д ирж зөвлөх багшаар ажиллахдаа гадаад хэлийг олон улсын харилцаатай холбож заах гэж хатуухан шаардсанаас болоод гадаад хэлний зарим багш нарын илд далд эсэргүүцэлтэй тулгарч байсныг тодхон санаж байна. Ер нь Монголд сайн ажилладаг, шударга хүнд тийм ч дуртай байдаггүй нэг зовлон бий.

Дүгэрсүрэн гуай хүнд өндөр шаардлага тавиад хүмүүсийг анхаарал халамж тавилгүй орхиж байсангүй. Сургууль төгсөөд удаагүй байсан миний биеийг олон улсын арга хэмжээ, НҮБ-ын чуулганд авч явж нүдийг маань нээж өгсөн ачтаныг яахан мартах билээ. Хожим нь ГЯЯ-ны мэдэлд эргэн ирэхэд Филатовагийн дотны хүмүүс надад ажил өгүүлэхгүй гэж бөгс ухаж байхад Дүгэрсүрэн л хамгаалж нам, төрийн тэргүүнтэй хүртэл уулзаж учрыг нь олж ажил өгч байлаа.

Тэрээр дипломат албан тушаалыг дээдэст долигонон бялдуучилж аваагүй. Өөрийн хөдөлмөрч чанар, оюуны өндөр чадавхи, ОУХ-ны үндсэн мэдлэг, гадаад хэл, төрөлх монгол хэлээ сайн эзэмшсэн гярхай, хэрсүү нэгэн байсны ачаар янз бүрийн дарамт шахалтын дор ажиллаж байсан хэдий ч бэрхшээлийг даван гарч байсныг нөхөд нь одоо ч дурсан ярьсаар байна.

1964 онд “Намын эсрэг бүлэг” гэгч нэр хоч зүүж цөлөгдсөн Лоохууз нарыг ялласан НТХ-ны бүгд хурлын завсарлагаар Цэдэнбал дарга Дүгэрсүрэнг өрөөндөө дуудаж “За Сүхбаатар жанжны хүргэн намайг дэмжинэ биздээ” гэхэд хар цагаан дуугүй сууж байгаад гарснаар хардлагад өртөх нэг гол сэжүүр болсон байх шүү. Тэр “бүлгийн” гишүүн Сурмаажавтай хамт Монголын гар бөмбөгийн нэгэн багт тоглож байсан спортын мастер цолтой хүн байв.

М.Дүгэрсүрэнтэй Москвагийн ОУХСургуульд хамт суралцаж байгаад хожим ГХ-ийн сайд болсон олон улсын эрх зүйч Содномын Аварзэд агсан Давст уул, Тагнын нуруу, Шишигтэйн голын сав газраас авах гол зорилготойгоор элчин сайдаар “томилогдон” ирсэн В.Молотовтой эр зориг, эх оронч сэтгэл гарган тулалдаж амьдрал амь насаараа хохирсон авьяаслаг дипломат, халуун эх оронч Аварзэдийг өмөөрч “Аварзэдэд ер нь юуны буруу байх вэ?” гэж өгүүлснийг нь олзуурхан миний бие бүтээлдээ¹ оруулсан юм.

¹ Д.Цолмон “Дипломат ёс горим, ёслол, баримт бичиг” (Гадаад бодлогын зарим асуудал) УБ. 2006

Түүний алба ажил тийм ч хөнгөн амар байгаагүй. Хүйтэн дайны сүүдэр Монгол улсын гадаад харилцаанд туссаар байсан үед энэ хариуцлагатай ажлыг хашиж байлаа.

1966 онд Улаанбаатар хот үер усны аюулд автаж хүний амь нас, эд хөрөнгө сүйдсэн тэр жил АНУ-ын “Нью Йорк таймс” сонины орлогч эрхлэгч Солсбери Монголд ирэхдээ ГЯЯ-ны сайд Дүгэрсүрэнтэй уулзаад “АНУ хэрэв Монголын ард түмэнд учирсан гамшгийг даван туулахад тусламж үзүүлбэ гэвэл та бүхэн хүлээн авах уу?” гэхэд нь талархал илэрхийлж тусламж өгвөл сайн л байна гэж хэлснийхөө төлөө “ЗХУ-ын өгөөмөр тусламж байсаар байтал Америкийн империалистуудаас тусламж авах” гэлээ гэж нэлээд бангадуулсан байдаг юм. Аль ч улсаас байгалийн гамшгийн үеэр туслая гэж байхад хариу талархал илэрхийлдэг нь соёлтой хүний хэлэх зүйл, дипломатын ёс зүйн асуудал гэж би хувьдаа бодож байна. Тэрээр “Нью Йорк таймс” сонинд хожим нь АНУ Монголтой дипломат харилцаа тогтоох цаг нь болсон тухай томоохон өгүүлэл нийтлүүлжээ. Эх оронч үзэл үндэсний эрх ашгийн асуудлыг амьд жишээтэйгээр ярьж гэж бодсон минь энэ болой.

Аливаа улс дипломат албаныхандаа өндөр үүрэг, хариуцлага ноогдуулдаг. Энэ тухай Францын судлаач Алан Плати дипломат төлөөлөгчийн газрын үүргийг бүтээлдээ 4 ангилж тодорхойлсон байна. Үүнд: төлөөлөх, мэдээлэх, хамгаалах, хэлэлцээ хийх².

Судлаач Жон Вүүд, Жан Серре нарын бүтээлд³ дипломат үйл ажиллагааг мэргэжил гэж онцлон тэмдэглээд ДТГ-ын үүргийг мөн дээрх чиглэлээр тодорхойлсон байдаг юм. Эдгээр санаа Монгол улсын дипломат албаны хуульд (2000) тусгасан ба дипломат ажилтны тангарагт эх орны язгуур эрх ашиг, нэр төрийг өндөрт өргөж явах санаа агуулсан байдаг.

1990-ээд оноос хойшхи Монгол улсын гадаад харилцаа, гадаад бодлогын салбарт томоохон өөрчлөлт гарлаа. Энэхүү чиг баримжаа Үндсэн хууль, Гадаад бодлогын болон Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд өмнөх үеэс огт өөрөөр туссан байна. Эдгээр он жилүүдэд алдаж онохын дэнсэнд эерэг сөрөг нэлээд зүйлтэй тулгарчээ. Хэрэв гадаадын зээл тусламж, хөрөнгө оруулалтыг үр дүнтэй, тооцоотой ашигласан бол чөлөөт зах зээлийн харилцаанд зүй зохистой шилжиж, хуучин хийж бүтээсэн зүйл, баазаа зөв ашиглах, өмч хувьчлалыг зөв явуулж, шилжилтийн улс төр, эдийн засгийн менежментийн зөв алхамууд хийж ардчиллыг жинхэнэ утгаар нь хөгжүүлсэн бол дэвжин хөгжих боломж

² Alain Plantey, *Principe De diplomatie Paris, 2000, p 262*

³ John Wood and Jean Serres “*Diplomatic Ceremonial and protocol*”. New York, 1970 p9-11

илүү л байлаа. Энэ нь нэг талаараа үүлэн чөлөөний нар туссан ч манай өмнөх зам харгуй тийм ч тод харагдахгүй үе байлаа.

Аливаа улсын гадаад бодлого, дипломат үйл ажиллагаа хоёр нягт холбоотой бөгөөд гадаад бодлого нь харьцангуй тогтвортой, хүн ардаа энх тунх, элбэг хангалуун аж төрөх, дэлхийн улс гүрнүүдийн дотор байр сууриа эзэлж, үндэсний эрх ашгаа дээдлэх чиглэлтэй байдаг билээ. Ухаантан, эх оронч үзэлтэй төрийн томоохон зүтгэлтэн, улс төрийн бодлогыг боловсруулагчид мөнхөд орших үндэсний ашиг сонирхлыг эрхэмлэн дээдэлж тэр нь хожмын үйлсийн мөнхийн жигүүр болдог авай. Дэлхийд нэртэй улс төр, нийгмийн зүтгэлтнүүдийн хэлсэн үг, судлаачдын нэлээд бүтээлүүд ийм санаа нэвт шингэсэн байдаг нь учиртай.

Төр улсаа хүндэтгэдэг, улсынхаа язгуур эрх ашгийг хамгаалдаг, нэр төрөө боддог, мэдлэг, мэргэжлийн зохих бэлтгэлтэй удирдах алба хашдаг хүнийг хаа ч хүндэлнэ. Тэд ч нэр төрөө бодно. Эрх чөлөө, ардчилал зохих хязгаартай бас хариуцлага шаардана. Гадаад оронд суугаа зарим дипломат, консулууд эх орноо орхин гадаадад цагаачилж, албан тушаалаа хувийн бизнест ашиглах нь олширчээ. Төрт ёсоо, дипломат ёс горимыг хүндэлдэггүй, эх орон, иргэдийнхээ ашиг сонирхлыг хамгаалдаггүй, хувийнхаа ачаа бараатай чингэлэг ачуулж суугаа дипломатууд олширсон тухай, түүнчлэн тамхи, архи, бүр хар тамхины хэрэгт монгол дипломатууд холбогдож улс орны нэр сүрийг сүрхий хохироож байгаа тухай бишгүй л мэдээлж байна. Улсын нэр хүндэд халтай ийм бизнесийн эзэд гэм зэмгүй л үлдсээр байх юм. Радио телевизээр Солонгос, Америкийн, эсвэл Германы виз түргэн гаргаж өгнө, “гадаадад баттай явуулна”, “гадаад хүнтэй гэрлэхэд зуучилна”, “царайлаг охидыг өндөр цалинтай ажилд зуучлана”, хэмээн гэнэн залуусыг маань хуурч хүнээр бизнес хийнэ гэдэг даан ч харамсалтай байна. Монгол төрийн хууль, бодлого байна уу гэж үе үе бодогдох боллоо. Засаг төр нь ч, иргэд нь сургамж авахгүй, хашрахгүй, тоохгүй явж иржээ.

Дүгэрсүрэн багшийн ойд зориулсан эссе бичлэгийн уралдаанд шалгарсан оюутан залуус найруулалдаа энэ тухай дурдаад эх орноо бодож ажиллах дүүрэн эрмэлзэлтэйгээр суралцаж байгааг нь үзээд их л олзуурхаж байна. Эдүгээ ГХЯ-ны бүрэлдэхүүний бараг 20 хувь нь МУИС-ийн ОУХС-ийн төгсөгчид байна.

Гадаад харилцаа, гадаад бодлогын салбарт гарсан олон ололт амжилтыг бүхэлд нь үгүйсгэж болохгүй л дээ. Зөвхөн засууштай бөгөөд улс орны аюулгүй байдал, нэр хүндэд хортой зарим нэг үйлдэл, болчимгүй хэрэг явдлын талаар сургамж, хойч үеийнхэнд санаж

явахад илүүдэхгүй зүйл хэмээн товч дурьдсан минь энэ юм. Улсын гадаад харилцаа намчирхах, нутгархах явдал, элдэв бүлгийн бас гэр бүлийн ашиг сонирхлоос ангид байх ёстой. Үүнд Япон мэтийн зарим улс орны туршлагыг үлгэр дууриал болгомоор байгаа юм.

Монгол улсын гадаад үйл ажиллагаа нэгдмэл, нэгэн зорилгод чиглэсэн, өнгөрсөн үеэсээ сургамж авсан, өнө хэтээн бодитой харж, хирдээ таарсан прагматик шинжтэй, бүхий л талаараа дотоод амьдралаа тохижуулахад тус дэм болж үндэсний эрх ашигт нийцсэн баймааж л туурга тусгаар улсынхаа гадаад байдлыг бэхжүүлж чадна.

Үүнд судалгаа мэдээлэл, ялангуяа эдийн засгийн дипломат ажиллагааг гадаадад суугаа дипломатууд, мэргэжилтнүүд сүрхий анхаарах хэрэгтэй юм.

Дүгэрсүрэн гуай гадаад албаны ажилтнуудыг мэдээллээс хоцрохгүй байхыг, үйл явдалд задлан шинжилгээ хийж сурахыг, санаачлагатай ажиллахыг үргэлж шаарддаг байлаа. Хүлээн авалт, ёслолын бусад арга хэмжээнд оролцохдоо суух зогсох газраа сайн мэдэхгүй булан бараадан дөлсөн дипломат ажилтан хааяа байдаг. Энэ нь тэр хүний сул тал боловч гол нь намын шалгуур, бүлгийн, гэр бүл хамаатан садны эрх ашгаа дээгүүр тавьж эх орноо төлөөлөх чадвар, суурь мэдлэгийг үл тоосны харгай мөн. Зарим элчин сайд гадаадаас төр засгийн өндөр хэмжээний төлөөлөгч айлчлуулахдаа ГХЯ-ндаа мэдэгдэлгүй шууд Ерөнхийлөгчтэй ярьдаг зовлон байдаг гэж гадаад албаныхан шүүмжлэлтэй хандаж байв. Соёлтой, туршлагатай дипломатууд ийм зүйл хийдэггүй. ГХЯ-ндаа мэдэгдээд Ерөнхийлөгчөөс давхар дэмжлэг авах нь хамгийн зохистой хэлбэр гэж үзнэ.

Ерөнхийлөгч төрийн тэргүүнд тухайн улсын хамгийн том дипломат байх учиртай. ГХЯ-ны ажилтны нэрийг барьж улсынхаа ерөнхийлөгчийн тухай гадаадын сэтгүүлд муучлан бичсэн нь үүрэг хариуцлагаа ухамсарлаагүй гадаад бодлого улсын нэр хүндийг бодоогүй, атгаг санаа нам бүлгийн зөрөлдөөнтэй холбоотой болчимгүй зүйл гэж бодно.

Ер нь үр ашиг муутай олон айлчлал зарим хувь хүнд ашигтай байдаг байх. Умард Солонгост Монгол улсын Ерөнхийлөгч айлчлахад Ерөнхийлөгч Ким Чин Эр хүлээж авалгүй хөдөө ажилтай гээд явчихсан тухай хэдэн жилийн өмнө мэдээлж байв. Энэ бол өөрсдийнхөө улсынхаа эрхэмсэг, нэр хүндийг бодолгүй зөвхөн би л болж байвал бусдад падлийгүй гэсэн өнөөгийн монгол сэтгэлгээний илрэл юм.

Даяаршлын эрин улс орнуудын оршин тогтнох, хүн ам зүй, эдийн засгийн, мэдээллийн, экологийн аюулгүй байдлыг ч хөндөж байна. Эмх замбараагүй, хууль ёсоон

мөрддөггүй төрийн түшээдтэй, бас улсын гадаад бодлого, дипломат ажиллагааны хариуцлагыг бүрэн үүрдэггүй байваас хөгжилтэй, олон хүн амтай хүчээ авсан, төрийн алсын хараатай бодлоготой улсын өмнө хүчин мөхөсдөж, эдийн засаг, улс төр, соёлын нөлөөнд нь уусан автах аюултай. Их бага улс гүрнүүд, ер нь аль улсад гадаад бодлогод нь байнга анхааран мөрддөг “Хар хайрцагны бодлого” заавал байх учиртай.

Дипломатын номлолын нэрт төлөөлөгч Жюль Камбон, орчин үеийн судлаачдаас Харольд Никольсон нар хуучин болон шинэ дипломатын арга өнгө нь өөрчлөгдсөн ч мөн чанар хэвээрээ үлдэнэ гэдэг дээр санал нийлсэн юм.

“Дотроо олон дуу хоолойтой байвч гаднаан (гадаадад) нэгэн дуутай байх” тухай хөрш орны гадаад бодлогын чиглэлээс санаа авууштай гэж бодном.

Дипломатууд түүний үйл ажиллагаа зөвхөн гадаадад сууснаар бус гол нь мэргэжлийн бэлтгэлтэй, үр өгөөжтэй байх учиртай. Харольд Никольсон гадаад бодлогыг мэргэжлийн хүмүүс хөтлөн явуулахын чухлыг тэмдэглээд мэргэжлийн бус дипломатууд өөртөө итгэлгүй байдгаас болж битүү хардалт, сэжигт автаж, хэт хичээнгүй, махруу ажиллаж, гэнэтийн сод санаа сэдэл гаргаж ирдэг гээд... түүгээр ч үл барам дипломат ёс горимыг үл тоомсорлон элэгсэг дотно байдал үзүүлэх гэж байгаа нь энэ гэж харилцагч этгээдийг эвгүй байдалд оруулдаг. Тайлан илтгэл нь баримт сэлтийн оронд уянгын халил ихтэй болдог гэжээ. Энэ нь Монголын дипломат албаныханд ч бас сургамжтай юм. Гэхдээ улс орныхоо дотоод амьдрал, хэрэгцээ шаардлага, онцлогийг мэддэг улс төрчдөөс дипломат ажилтан болохыг ор тас үгүйсгэж туйлширч болохгүй гэж бодном.

Хүн авьяас билэг, мэргэжлийн хажуугаар шударга эх оронч зан чанараар үнэлэгддэг гэж сонгодог дипломат ажиллагааны ном сударт өгүүлдэг юм. Мөнхөд орших үндэсний эрх ашгаа дээдэлсэн, эх оронч, идэвхтэй, олон улсын харилцаа хийгээд улс орныхоо гадаад, дотоод орчинг мэддэг тийм л хүмүүс эх оронд, Монголын гадаад албанд илүү шаардлагатай байна.

Монголын дипломат алба, МУИС-ийн ОУХС-ийн түүхэнд Мангалын Дүгэрсүрэнгийн нэр алдар мөнх дуурсагдан үлдэнэ гэдэгт бат итгэж байна.

Санал:

1. М.Дүгэрсүрэнгийн нэрэмжит оюутны Эссе бичлэгийн уралдааныг жил бүр уламжлал болгон зохион байгуулж байх,
2. Дүгэрсүрэн багшийн амьдрал үйл ажиллагааг харуулсан тусгай самбар булантай болох нь зүйтэй гэж үзнэ.